



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар #298

Улаанбаатар хот

Албан тушаалын үлгэрчилсэн
тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 03/1664 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн нэгдсэн эмнэлгийн захирлын албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалаар баталсан албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Төгсдэлгэр)-д даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141224299

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
08 дугаар сарын 18-ний өдрийн
А/238 дугаар тушаалын хавсралт

**АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

2023 оны дугаар сарын-ны өдрөөс

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны ... дугаар сарын-ны өдөр

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

..... аймгийн нэгдсэн эмнэлэг

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эмнэлгийн захирал

ТҮЭМ-8

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, аймгийн хүн амд үндсэн мэргэшлийн болон нэн шаардлагатай зарим төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг

үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Засаг даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;
2. Аймгийн хүн амд үндсэн мэргэшлийн болон нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;
3. Байгууллагын гүйцэтгэлийн болон стратегийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүгийн тогтвортой, үр ашигтай байдлыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;
4. Аймгийн эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас бусад мэргэшлийн чиглэлээр зөвлөгөө авах;
5. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй ба үндсэн мэргэшлийн сургалт зохион байгуулах;
6. Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцах, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1 эрүүл мэндийн бодлого, хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэр боловсруулахад оролцох ажлыг удирдлагаар хангах	санал өгсөн бодлого, хууль тогтоомжийн тоо	Г,Х, Ш
	1.2 хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эмнэлгийн хэмжээнд зохион байгуулах	хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
	1.3 эрүүл мэндийн урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөр, стратеги, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагын түвшинд хэрэгжүүлэх, орон нутгийн бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэшлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	холбогдох бодлого, хөтөлбөр, стратеги, арга хэмжээний төлөвлөгөөний байгууллагын түвшний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш

	1.4 аймгийн иргэдэд эмнэлгийн үндсэн ба нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нөөцөөр хангах	нөөцийн хангалтын хувь	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	2.1 аймгийн хүн амд үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээг хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх	нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
	2.2 аймгийн хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан зарим нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх		Г, Х, Ш
	2.3 эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, чанарын үзүүлэлтийг ханган ажиллах	эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн түвшин	Г, Х, Ш
	2.4 эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
	2.5 тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлаар нотолгоонд суурилсан санал боловсруулах, холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх	тухайн жилд шинээр нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний үр дүн	Г, Х, Ш
	2.6 гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдал, нөөцийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулах	тухай бүр шинэчилж баталсан гамшиг, онцгой байдлын үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш

	2.7 үйлчилгээний соёлыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	үйлчилгээний соёлтой холбоотой гарсан гомдлын тоо	Г, Х, Ш
	2.8 эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааг ойлгомжтой, чанартай олон сувгаар хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах	тухайн жилд иргэдэд зориулан гаргасан мэдээлэл, сургалт сурталчилгааны тоо, төрөл, хандалтын тоо	Г, Х, Ш
	2.9 эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эмгэгийг эрт илрүүлэх үзлэг оношилгоог зохион байгуулах	эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтын хувь	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1 байгууллагын стратеги төлөвлөгөөг үндэсний болон салбарын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, тусламж, үйлчилгээний тэгш байдал, чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангахад чиглүүлэн хэрэгжүүлэх	байгууллагын дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
	3.2 гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн зорилттой уялдуулан жил бүр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
	3.3 хүний нөөцийн хэрэгцээг өөрийн байгууллагын түвшинд тооцон төлөвлөлт хийх, хүний нөөцийг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөлтийн биелэлтийн хувь	Г, Х, Ш
	3.4 хүний нөөцийг хөгжүүлэх, сургах, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	- ажилтнуудын ёс зүйн зөрчлийн тоо - ажиллах нөхцөл нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш

	3.5 төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, тогтвортой байдлыг хангаж, өр авлагагүй ажиллах	- өр, авлагын хэмжээ - санхүүгийн аудитын дүгнэлт	Г, Х, Ш
	3.6 байгууллагын хөгжил, хүний нөөцийг чадавхижуулах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, мэдээллийн технологийг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээг өргөжүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, бусад байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	хамтын ажиллагааны үр дүнг тооцсон тайлан	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1 эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр аймгийн бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэшлийн арга зүйгээр хангах	аймгийн бусад эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгсөн тоо	Г, Х, Ш
	4.2 бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бусад лавлагаа төвөөс мэргэшлийн арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах	арга зүйн зөвлөгөө авсан тоо	Г, Х, Ш
	4.3 нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн Онцгой байдлын газар, орон нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэшлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх	нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гарсан үндэслэлтэй алдаа дутагдал, гомдол саналын тоо	Г, Х, Ш
	5.1 эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг хууль, журмын дагуу мэргэжлийн нийгэмлэг, холбоо, бусад сургалт эрхлэх байгууллагатай хамтран зохион байгуулах	аймаг, байгууллагын түвшинд бие даан болон хамтран зохион байгуулсан төгсөлтийн дараах тасралтгүй сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	Г, Х, Ш

	5.2 эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг хууль журмын дагуу авч, аймгийн эрүүл мэндийн бусад байгууллагатай сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэж, орон нутагтаа зохион байгуулах	нэгдсэн эмнэлэгт төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	Г, Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	5.3 аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, бусад хариуцсан асуудлаар орон нутгийн удирдлага, ЭМЯ, Эрүүл мэндийн газар, бусад төрийн байгууллагуудыг үнэн зөв мэдээ, мэдээллээр тогтоосон цаг хугацаанд нь хангах	шаардлагатай мэдээ, мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн хувь	Г, Х, Ш
	6.1 эмнэлгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, тасаг, нэгж, албадын дарга нарын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалт, арга зүйгээр хангах, хяналт тавих	байгууллагын жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний дүн	Г, Х, Ш
	6.2 хууль, тогтоомж, бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал шийдвэр гаргах, эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах	шүүхийн маргаан үүссэн шийдвэрийн тоо, шийдвэрлэлтийн хувь	Г, Х, Ш
6 дугаар зорилтын хүрээнд	6.3 батлагдсан төсөв, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг зохицуулан ажиллах	орон тоо, цалингийн сангийн хэтрэлтийн хэмжээ	Г, Х, Ш
	6.4 ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэх, ажилтнуудад ажлын үр дүнгээр нь урамшуулал олгох, хариуцлага тооцох	олгосон урамшууллын төрөл, хэмжээ	Г, Х, Ш
	6.5 байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	- ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн түвшин - сул ажлын байранд нээлттэй сонгон	Г, Х, Ш

		шалгаруулж авсан ажилтны хувь	
6.6 авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах нөхцлийг бүрдүүлэх		- авлига ашиг сонирхлын зөрчлийн тоо, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
6.7 үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулах ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх		байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Г, Х, Ш
6.8 иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах		иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	Г, Х, Ш
6.9 томилох эрх бүхий ажилтны холбогдох шийдвэрийн дагуу гадаад, дотоод томилолтоор ажиллах		холбогдох шийдвэргүйгээр гадаад, дотоод томилолтоор ажилласан тоо	Г, Х, Ш
6.10 хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх		- захирлын хөдөлмөрийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан зөрчлийн тоо - сахилгын шийтгэл хүлээсэн эсэх	Г, Х, Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	Анагаах ухаан /091201/	
Мэргэшил	- Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн байх (Эрүүл мэнд/эмнэлгийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн баримт бичиг, түүнтэй дүйцэхүйц буюу эрүүл мэнд/эмнэлгийн удирдлагын чиглэлээр боловсролын зэрэг олгосныг нотлох баримт бичигт тус тус үндэслэнэ).	
Туршлага	-Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил, төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан байх; -Эрүүл мэндийн байгууллагад 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион	- байгууллагын бодлого, стратегийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт

байгуулах	<p>тавих;</p> <ul style="list-style-type: none"> - байгууллагын нэгж хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийг дүгнэх, шаардлага тавих; - батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах; - байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - үйл ажиллагааны эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг боловсруулах, хяналт тавих; - албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих.
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэлд тулгуурлан байгууллагын бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх; - шийдвэрийн төслийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - судалгаа шинжилгээний үр дүн, статистик тоо мэдээллийг шинжилж, дүгнэлт өгөх; - байгууллагын дотоод үйл ажиллагааны тулгамдсан асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх.
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөө, гаргасан шийдвэрийнхээ үндэслэл, үнэн зөв байдлын үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;
Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах; - салбарын болон байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо ойлгуулах, хэрэгжүүлэх; - шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалтын хувьд үлгэр дуурайл үзүүлэх.

	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах компьютерийн програм, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - байгууллагад хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэх; - төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах, мэдээллийг хүргэх; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах.
--	-------	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
Батлагдсан бүтэц, орон тооны дагуу	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар бусад төрийн байгууллагууд; - аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар; - Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бусад эрүүл мэндийн байгууллага; - анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулиуд, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхэлдэг байгууллага, нийгэмлэг, холбоод, мэргэшлийн салбар зөвлөл; - олон улсын байгууллагууд, тэдгээрийн төсөл хөтөлбөрийн нэгж; - төрийн бус байгууллагууд; - хэвлэл мэдээллийн байгууллагууд; - иргэд, бусад аж ахуйн нэгж байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, санал өгсөн байгууллагын шийдвэр:
--	--

Ажлын хэсгийн ахлагч:	Байгууллагын нэр: Төрийн албаны зөвлөл
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2023 оны ... сарын ... -ны өдөр	Шийдвэрийн огноо: 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдөр
	Дугаар: 03/1664 тоот албан бичиг

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

Албан тушаал:

Шийдвэрийн огноо:

Дугаар:
(тамга/тэмдэг)

.....
(Гарын үсэг)

.....
(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны дугаар сарын-ны өдөр